



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/663

Булган сум

**Орос хэлний багшийн байрны түрээсийн зардалд
дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXV/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Оросын Холбооны Улсын Боловсролын яамны Олон улсын хамтын үйл ажиллагааны төвтэй байгуулсан "Боловсролын салбарт үйлчилгээ үзүүлэх тухай" гэрээгээр Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд ажиллах Орос хэлний багшийн байрны түрээсийн зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Байрны түрээсийн зардалд шаардагдах 9,600,000 (есөн сая зургаан зуун мянга) төгрөгийг "Шинэ Ирээдүй" хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

